Тайлант оны зорилгыг “Удирдлагын орчин үеийн дэвшилттэй арга барил, туршлагыг нэвтрүүлэн, төрийн албаны ажилтны мэдлэг, чадварыг ахиулж, төрийн байгууллагын чадавхыг дээшлүүлэх чадвартай бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох, хууль тогтоомж, хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөө, зорилтыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавих, хуулийн хүрээнд ажиллах” гэж тодорхойлсон байна.

Дээрх зорилгын хүрээнд “Төрийн үйлчилгээг ард иргэдэд хөнгөн шуурхай үйлчлэх, хууль тогтоомжийг хүргэж ойлгуулах, төсвийг зүй зохистой зарцуулах, ил тод болгох” гэсэн зорилтыг дэвшүүлэн ажилласан байна.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

##### ***Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар***

Өлгий сумын Засаг дарга нь Засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь тус аймгийн төсөвт байгууллагуудын санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага юм. Тус албанаас 2024 онд Өлгий сумын ТТЗ-ийн харьяа байгууллагуудаас Хоршоо хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### **Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар**

Өлгий сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2020 онд баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг мөрдлөг болгон ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дугаар тушаалаар баталсан "Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 8,981.5 сая төгрөгөөр буюу 32.7 хувиар өссөн байна.

#### *Хүснэгт №1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	303.2	561.0	257.8
Авлага	905.5	901.8	-127
Урьдчилгаа	0.0	17.7	10
Бараа материал	345.6	442.6	-67.2
Нөөцийн бараа	0.0	27.6	-8.9
Үндсэн хөрөнгө	25914.0	34499.0	61.2
<b>Нийт хөрөнгө</b>	<b><u>27,468.3</u></b>	<b><u>36,449.7</u></b>	<b><u>8,981.5</u></b>
Өр төлбөр	395.1	1302.2	907.1
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	27073.1	35147.5	8074.4
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b><u>27468.3</u></b>	<b><u>36449.7</u></b>	<b><u>8981.5</u></b>

*Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан*

Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлтүүдээс харахад мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилгаа, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо данснуудад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 561.0 сая төгрөг болж, оны эхнээс 257.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>303.2</b>	<b>561.0</b>	<b>257.8</b>
Банканд байгаа бэлэн мөнгө	303.2	561.0	257.8
Төгрөг	303.2	561.0	257.8
Төрийн сангийн харилцах	303.2	561.0	257.8

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Мөнгөн хөрөнгө данс үлдэгдэл оны эхнээс 257.8 сая төгрөгөөр өссөн нь орон нутгийн ерөнхий орлогын данс, ОНХС, ХХС-ийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нэмэгдсэнтэй холбоотой байна. Орон нутгийн ерөнхий орлогын данс 84.5 сая төгрөгийн, ОНХС-гийн данс 85.9 сая төгрөгийн, Хоршоо хөгжүүлэх сангийн данс 390.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар болон харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар мөнгөн хөрөнгө данстай холбоотой зөрчил гараагүй.

### 3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 901.8 сая төгрөг болж, оны эхнээс 3.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №3. Авлагын үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	1.8	3.7	1.9
Төлбөртэй үйлчилгээний авлага	113.5	297.7	184.2
Байгууллагаас авах авлага	0.0	17.0	17.0
Хувь хүмүүст олгосон зээл	790.1	583.4	-206.7
<b>Дүн</b>	<b>905.4</b>	<b>901.8</b>	<b>-3.6</b>

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хувь хүмүүст олгосон зээлийн үлдэгдэл 206.7 сая төгрөгөөр буурсан бол ажиллагчидтай холбогдсон авлага 1.9 сая төгрөгөөр, төлбөртэй үйлчилгээний авлага 184.2 сая төгрөгөөр, байгууллагаас авах авлага 17.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Аудитын илрүүлэлт:

ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар болон харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн авлага данстай холбоотой алдаа, зөрчил илрээгүй байна.

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

### 3.4.3 Урьдчилгаа

Урьдчилж гарсан зардал данс оны эхэнд үлдэгдэлгүй ба оны эцэст 17.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

#### Хүснэгт №4

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	0.00	17.7	17.7
<b>Дүн</b>	<b>0.00</b>	<b>17.7</b>	<b>17.7</b>

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

#### Аудитын илрүүлэлт:

ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар болон харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар урьдчилгаа данстай холбоотой зөрчил гараагүй.

### 3.4.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 442.6 сая төгрөг болж, оны эхнээс 97.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

#### Хүснэгт №5. Бараа материалын үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалттай материал		<b>0.3</b>	<b>0.3</b>
Эм боох материал	119.7	186.6	66.9
Бичиг хэргийн материал	<b>0.7</b>	<b>0.6</b>	<b>-0.1</b>
Аж ахуйн материал	182.6	175.2	-7.4
Сэлбэг хэрэгсэл	11.3	26.9	15.9
Түлш шатах тослох материал	22.3	46.9	24.6
Бусад хангамжийн материал	9.0	6.0	-3.0
<b>Дүн</b>	<b>345.6</b>	<b>442.6</b>	<b>97.0</b>

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Бараа материалын данс 97.0 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Өрхийн эмнэлгийн бараа материал 94.1 сая төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

#### Аудитын илрүүлэлт:

ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар болон харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар бараа материалын данстай холбоотой зөрчил илрээгүй байна.

### 3.4.5 Бусад эргэлтийн хөрөнгө:

Нөөцийн бараа дансанд оны эхэнд үлдэгдэлгүй байсан ба оны эцэст 27.6 сая төгрөгийн тэжээлийн нөөцийн үлдэгдэлтэй байна.

### 3.4.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 41,759.5 сая төгрөг болж, оны эхнээс 11.0 сая

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 6. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Биет хөрөнгө</b>	<b>26,327.84</b>	<b>37,331.39</b>	<b>11,003.55</b>
Барилга, байгууламж, орон сууц	2,036.70	2,722.78	686.08
Авто-тээврийн хэрэгсэл	1,307.78	1,369.30	61.53
Машин тоног төхөөрөмж(компьютер)	694.79	959.05	264.26
Тавилга, аж ахуйн эд хогшил	197.54	235.27	37.73
Зам, гүүрийн байгууламж	15,095.74	23,706.39	8,610.65
Номын фонд	16.87	16.87	0.00
Бусад үндсэн хөрөнгө	6,978.42	8,321.72	1,343.31
<b>Биет бус хөрөнгө</b>	<b>4,404.04</b>	<b>4,428.14</b>	<b>24.10</b>
Программ хангамж	5.10	5.87	0.77
Бусад биет бус хөрөнгө	4,398.94	4,422.27	23.33
<b>Дүн</b>	<b>30,731.88</b>	<b>41,759.53</b>	<b>11,027.65</b>

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Үндсэн хөрөнгийн данс өссөн нь сумын Засаг даргын тамгын газрын аймаг, сумын Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр үнэ төлбөргүй хөрөнгө хүлээн авсантай холбоотой байна.

#### Аудитын илрүүлэлт:

ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар зөрчил гараагүй.

Сумын ИТХ-ын жилийн эцсийн үндсэн хөрөнгө болон бараа материалын тооллого хийгээгүй байна.

Сумын ЗДТГ нь нийтдээ 33.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг төрийн цахим худалдан авалтын тухай хууль тогтоомжийг зөрчиж худалдан авсан байна.

Сумын Орон нутаг хөгжлийн сангийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар тоног төхөөрөмж нийлүүлэх, хяналтын камер суурилуулах нийтдээ 54.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг 6 ажил болгож хуваан босго үнэд багтаах зорилгоор төсөвт өртгийг хувааж, сумын Иргэдийн төлөөгчдийн хурлын тогтоолоор батлуулан гэрээ шууд байгуулж гүйцэтгүүлэн, төрийн цахим худалдан авалтын тухай хууль тогтоомжийг зөрчсөн байна.

### 3.4.7 Өр төлбөр

Өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл 1,302.2 сая төгрөг болж, өмнөх оноос 907.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №7

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажилчидтай холбогдсон өглөг	23.9	105.5	81.6
Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.0	164.6	164.6
Татаас, санхүүжилтийн өглөг	304.4	304.4	0.0
Байгууллагад төлөх өглөг	66.8	725.7	658.9

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Хувь хүмүүст төлөх өглөг	0.00	1.9	1.9
<b>Дүн</b>	<b>395.1</b>	<b>1,302.2</b>	<b>907.1</b>

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Өглөгийн дансны үлдэгдэл өмнөх оноос 907.1 сая төгрөгөөр нэмэгдэхэд Өрхийн эмнэлэг ажилчидтай холбоотой 105.5 сая төгрөгийн өглөгтэй гарсан, Өлгий сумын цэцэрлэг, сургуулиуд 690.9 сая төгрөгийн тогтмол зардлын өглөгтэй гарсан нь нөлөөлсөн байна.

#### Аудитын илрүүлэлт:

*ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар өр төлбөр данстай холбоотой зөрчил гараагүй.*

*Сумын ИТХ-ын санхүүгийн тайланд хийсэн аудитаар Иргэдийн нийтийн хурлын дарга нарын урамшууллаас суутгасан 2.2 сая төгрөгийн хувь хүний орлогын албан татварыг төсөвт төвлөрүүлээгүй, санхүүгийн тайланд өглөгөөр тусгаж харуулаагүй байна.*

*Хот тохижуулах алба ажиллагсдын цалингаас суутгасан 310.0 мянган төгрөгийн татварыг төсөвт төвлөрүүлээгүй, санхүүгийн тайланд өглөгөөр тусгаж харуулаагүй байна.*

### 3.4.8 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 35,147.5 сая төгрөг болж, тайлант оны үр дүнгийн хэмжээгээр 8,051.1 сая төгрөг болон Засгийн газрын оруулсан капиталын өөрчлөлтийн оны эхний болон эцсийн 23.3 сая төгрөгийн өөрчлөлтийн хэмжээгээр өссөн байна.

Хүснэгт №8 Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	/ сая төгрөгөөр		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>27,073.1</b>	<b>35,147.5</b>	<b>8,074.4</b>
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	5,519.1	5,542.4	23.3
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>21,060.5</b>	<b>29,111.6</b>	<b>8,051.1</b>
Өмнөх үеийн үр дүн	19,389.9	21,060.5	1,670.6
Тайлант үеийн үр дүн	1,670.6	8,051.1	6,380.5
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	493.5	493.5	0.00
<b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>27,468.3</b>	<b>36,449.7</b>	<b>8,981.4</b>

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Өлгий сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 9 хөтөлбөрт зориулан нийтдээ 9,159.3 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 8,291.4 сая төгрөгийг урсгал зардалд, 867.9 сая төгрөгийг хөрөнгийн зардалд баталжээ.

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Нийт зардлын 8,116.4 сая төгрөгийг сумын орон нутгийн төсвийн орлогоос, 839.9 сая төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлэхээр, 175.0 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 28.0 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс бүрдүүлэхээр төлөвлөжээ.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2024 онд гүйцэтгэлээр нийтдээ 9,189.2 сая төгрөгийн санхүүжилтийн орлого бүрдүүлснээс орон нутгийн татварын орлогоос 7,885.5 сая төгрөгийн, Орон нутгийн хөгжлийн сангаас 805.4 сая төгрөгийн санхүүжилт хүлээн авч, үндсэн үйл ажиллагааны орлогоос 242.5 сая төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 8,677.8 сая төгрөг буюу 94.7 хувьтай гарч, Орон нутгийн хөгжлийн сан 85.9 сая төгрөгийн, Хоршоо хөгжүүлэх сан 390.5 сая төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдэлтэй байгаатай тус тус холбоотой байна.

#### *Аудитын илрүүлэлт*

*Сумын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар зөрчил гараагүй.*

*Сумын ИТХ-ын санхүүгийн тайланд хийсэн аудитаар:*

*Хурлын нарийн бичгийн даргад 9 дүгээр сард олгосон цалингийн урьдчилгааг суутгаагүй, мөн 4 ажилтанд нэг сарын цалинг тушаал шийдвэрэгүйгээр илүү олгож, цалингийн зардлаас нийтдээ 8,183,000 төгрөгийг бодож олгож, төсвийн зориулалт бус зарцуулсан зөрчилд төлбөрийн акт тогтоосон.*

*Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчдад 5 жил тутам нэг удаа олгох мөнгөн урамшууллаас 1,634.7 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татварыг суутгаагүй олгосон.*

*Бараа үйлчилгээний бусад зардлын төсвөөс 93.0 сая төгрөгийг сумын ИТХ-аас ямар нэг шийдвэр гараагүй байхад сумын иргэдийн төлөөлөгчдийн үйл ажиллагаанд зарцуулж үйл ажиллагааны тайланг гаргуулж аваагүй, анхан шатны баримтыг зохих журмаар бүрдүүлж баримтжуулаагүй байна.*

*Тээвэр шатахууны зардлаас 14.3 сая төгрөгийн шатахууны замын хуудсыг хөтөлж баримтжуулаагүй, тооцоог хийгээгүй, шатахууныг бүх ажилтнуудад хяналтгүй олгосон, албан томилолтын баримтын бүрдлийг хангаагүй, төсвийн зарцуулалтад тавих дотоод хяналтыг хангалтгүй хэрэгжүүлж, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг байна.*

*Сумын ЗДТГ-ын санхүүгийн тайланд хийсэн аудитаар:*

*- Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчдад 5 жил тутам нэг удаа олгох мөнгөн урамшууллаас 4.8 сая төгрөгийн хувь хүний орлогын албан татварыг суутгаагүй олгосон.*

*- Санхүүгийн албаны дарга, төрийн сангийн мэргэжилтэн, нягтлан бодогч нарт газрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар зөрчилгүй дүгнэлт авсан гэж 4.9 сая төгрөгийн урамшуулал олгож, төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын хэмжээг хэтрүүлсэн байна.*

*- Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжсэн гэрээний дүн нь 182.0 сая төгрөгийн “Гэрэлтүүлэг шинээр татах ажил”-ыг 10 ажил болгож, гэрээний дүн нь 90.0 сая төгрөгийн өртөгтэй “Гэрэлтүүлгийн засварын ажил”-ыг 7 ажил болгож, гэрээний*

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

дүн нь 144.0 сая төгрөгийн багуудын “гүний худаг гаргах” ажлыг 8 ажил болгож хуваан босго үнэд багтаах зорилгоор төсөвт өртгийг хувааж, сумын Иргэдийн төлөөгчдийн хурлын тогтоолоор батлуулан гэрээ шууд байгуулж гүйцэтгүүлсэн байна.

Хот тохижуулах алба хог тээвэрлэх үйлчилгээ, хогийн цэгийн ажилд нийтдээ 173.4 сая төгрөгийн шатахуун зарцуулснаас 82.0 сая төгрөгийн шатахууны замын хуудас, бүртгэлийг хөтлөөгүй, төсвийн зарцуулалтад тавих дотоодын хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

### **Сумын орон нутгийн төсвийн орлогын талаар:**

Өлгий сумын ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 63 дугаар тогтоолоор сумын 2024 орлогын төлөвлөгөөг 14,335.1 сая төгрөгөөр баталсан байна.

Аймгийн ИТХ-ын хуралдааны “2024 оны төсөвт тодотгол хийх тухай” 262 дугаар тогтоолоор Өлгий сумын орон нутгийн орлогын төлөвлөгөөг 18,093.4 сая төгрөгөөр тодотгож баталсан байна. Өлгий сумын ИТХ-ын 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн “Өлгий сумын 2024 оны төсвийг тодотгон батлах тухай” 87 дугаар тогтоолоор 2024 орлогын төлөвлөгөөг анх баталснаас 4,531.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж 18,867.0 сая төгрөгөөр тодотгож баталсан байна.

Гүйцэтгэлээр тайлант онд 17,097.9 сая төгрөгийн орлого оруулсан ба орлогын төлөвлөгөө 1,769.0 сая төгрөгөөр буюу 9.4 хувиар тасарсан байна.

Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын татварын орлогоос ХХОАТ-ын буцаан олголтод 978.6 сая төгрөг олгосон байна.

#### **Хүснэгт №9 Орон нутгийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл**

<u>Үзүүлэлт</u>	<u>Төлөвлөгөө</u>	<u>Гүйцэтгэл</u>	<u>Өсөлт/+, бууралт /-/ /сая төгрөг/</u>	<u>Дүнд эзлэх хувь</u>
I.Татварын орлого	18,027.8	16,604.4	-1,423.4	92.1%
II.Татварын бус орлого	839.3	493.6	-345.6	-1.5%
<b>Нийт дүн</b>	<b>18,867.0</b>	<b>17,097.9</b>	<b>-1,769.0</b>	<b>90.6%</b>

Эх сурвалж: Аудитын судалгаа

ХХОАТ-ын орлого 1,280.9 сая төгрөгөөр, өмчийн татвар 96.8 сая төгрөгөөр, бусад татвар 45.7 сая төгрөгөөр, татварын бус орлого 345.6 сая төгрөгөөр тасарсан байна.

Орлогын нэр төрлөөр задалж авч үзэхэд:

Хувь хүний орлогын албан татвар нийт дүнгээрээ 1,280.9 сая төгрөгөөр тасарсны дотор цалин хөлс түүнтэй адилтгах орлогын албан татвар 1,748.0 сая төгрөгөөр, хөрөнгө борлуулсны орлогын татвар 17.3 сая төгрөгөөр тасарч, хөрөнгийн орлогын албан татвар 25.9 сая төгрөгөөр, үйл ажиллагааны албан татвар 458.6 сая төгрөгөөр давж биелэгдсэн байна.

Өмчийн татвар нийт дүнгээрээ 96.8 сая төгрөгөөр тасарсан ба бууны албан татвар 0.3 сая төгрөгөөр, үл хөдлөх хөрөнгийн татвар 96.5 сая төгрөгөөр тасарсан байна.

Бусад татвар нийт дүнгээрээ 45.8 сая төгрөгөөр тасарсны дотор түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 45.5 сая төгрөгөөр, хог хаягдлын хураамж 53.9 сая төгрөгөөр тасарч, улсын тэмдэгтийн хураамж 12.9 сая төгрөгөөр, газрын төлбөр 35.4 сая төгрөгөөр, малын татвар 5.3 сая төгрөгөөр давж биелэгдсэн байна.

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Татварын бус орлого нийт дүнгээрээ 345.6 сая төгрөгөөр тасарсаны дотор торгуулийн орлого 487.2 сая төгрөгөөр тасарч, нэр заагдаагүй бусад орлого 141.5 сая төгрөгөөр давж биелэгджээ.

Орон нутгийн ерөнхий орлогын 910 тоот дансанд оны эхэнд 82.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй ба Орон нутгийн орлогын 995 тоот дансаар 18,076.5 сая төгрөгийн татварын орлого оруулж, 18,074.4 сая төгрөгийн төсвийг зарцуулж, оны эцэст орон нутгийн төсвийн ерөнхий орлогын 910 тоот дансанд 84.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Хүснэгт №10 Төсвийн байгууллагуудын төсвийн гүйцэтгэлтийн талаар:

№	Байгууллагын нэр	2023 оны		Зөрүү	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	дүнгээр	хувиар
1	Сумын ИТХурал	448.40	404.13	(44.27)	90%
2	Сумын ЗДТГазар	2,324.28	2,239.41	(84.88)	96%
3	Хот тохижуулах алба	1,580.80	1,580.80	-	100%
4	Сум хөгжүүлэх сан	175.00	22.91	(152.09)	13%
5	ОНХСан	867.91	768.32	(99.59)	89%
	<b>Орон нутгийн дүн</b>	<b>5,396.39</b>	<b>5,015.56</b>	<b>(380.83)</b>	<b>93%</b>
1	Ерөнхий боловсролын сургуулиуд	2,121.12	2,084.86	(36.25)	98%
2	Хүүхдийн цэцэрлэгүүд	1,634.28	1,572.17	(62.11)	96%
3	Хотгор эрүүл мэндийн төв	7.52	5.18	(2.34)	69%
4	<b>Тусгай шилжүүлгийн дүн</b>	<b>3,762.91</b>	<b>3,662.21</b>	<b>(100.70)</b>	<b>97%</b>
	<b>Нийт дүн</b>	<b>9,159.30</b>	<b>8,677.77</b>	<b>(481.53)</b>	<b>95%</b>

*Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан*

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2024 онд нийт 9,159.3 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр 8,677.8 сая төгрөгийн төсвийг зарцуулж 95 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна. Үүнд: Сумын ИТХ 44.4 сая төгрөгөөр, ЗДТГ 84.9 сая төгрөгөөр, Хоршоог хөгжүүлэх сан 152.1 сая төгрөгөөр, Орон нутгийн хөгжлийн сан 99.6 сая төгрөгөөр төлөвлөснөөс бага гүйцэтгэлтэй гарсан байна.

Сумын Орон нутгийн хөгжлийн сан төлөвлөснөөс бага гүйцэтгэлтэй гарсан нь зарцуулалттай, Хоршоог хөгжүүлэх сан төлөвлөснөөс бага гүйцэтгэлтэй гарсан нь олгосон зээлийн хэмжээтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Тайлант онд сумын ИТХ, ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд ЗГНХ, ЗДНХөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөөс 104.3 сая төгрөгийн, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 76.0 сая төгрөгийн нийтдээ 180.3 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авсан байна. Үүнээс: Тээвэр шатахууны зардалд 1.9 сая төгрөгийг, бараа үйлчилгээний бусад зардалд 175.9 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн гүйцэтгэл, орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2024 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Назгүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн тайланг 2024 оны 3 дүгээр сарын 06-ны өдрийн 01/104 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 13,565.1 сая төгрөгөөс 1 хувиар тооцож 135.6 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж үзээд шинэчилж тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор сумын төсөв байгууллагууд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй батлагдсан төсөвтөө багтаан үйл ажиллагаа явуулсан байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах асуудлын хүрээнд үйл ажиллагаатай хамааралтай 2 шалгуурт алдаа, зөрчил илрээгүй байна.

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн Шилэн дансны мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгахад шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд төсвийн төвлөрүүлэн захирагчийн шилэн дансны мэдээлсэн байдлын хэрэгжилт 98.3 хувь, хугацаа хоцролтын хэрэгжилтийн хувь 99.4 хувьтай байна.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх 2023 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй байна.

### **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

---

#### **5.1. Сумын ТТЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн алдаа зөрчлийн талаар:**

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 3 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 1 байгууллага, 2 сангийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудаас Засаг даргын тамгын газрын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн. Сумын ИТХ, Хот тохижуулах алба, Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сангийн тайланг түүвэрт хамруулж үзсэн.

Ерөнхий боловсролын 11 сургууль, Хүүхдийн 27 цэцэрлэг, Өрхийн Эрүүл мэндийн төвүүд, Хотгор багийн Эрүүл мэндийн төв зэрэг нийт 40 байгууллагын орон нутгийн төсвөөс олгосон тогтмол зардлын санхүүжилтийг нэгтгэлд хамруулсан байна.

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 1,049.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 17.7 сая төгрөгийн зөрчилд 5 төлбөрийн акт тогтоож, 692.2 сая төгрөгийн зөрчилд зөрчил арилгах 6 албан шаардлага, 339.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах 4 заалт бүхий зөвлөмж өгөгдсөн. ИТХ-ын 2 албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлсэн.

Сумын бусад төсөвт байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 2,253.2 сая төгрөгийн зөрчил илэрснээс 929.1 сая төгрөгийн 45 алдааг санхүүгийн тайланд залруулж, 29.3 сая төгрөгийн зөрчилд 4 төлбөрийн акт тогтоож, 679.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах 39 албан шаардлага, 615.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах 55 зөвлөмж өгсөн. Өлгий сумын 2 дугаар цэцэрлэгийн 2 албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлсэн.

Хүснэгт №11 Төсөвт байгууллагуудын алдаа зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/Д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс							
		Тоо	Дүн	Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Өлгий сумын ЗДТГ	3	43.8			1	4.9	2	38.9		
2	Өлгий сумын ИТХ	7	264.3			3	12.5	3	237.3	1	14.5
3	Хот тохижуулах алба	3	325.1			1	0.3			2	324.8
4	Өлгий сумын ОНХС	1	416					1	416.0		
5	Өлгий сумын ХХС	1	0							1	
<b>Орон нутгийн байгууллагын дүн</b>		<b>15</b>	<b>1049.2</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>5</b>	<b>17.7</b>	<b>6</b>	<b>692.2</b>	<b>4</b>	<b>339.3</b>
1	Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль	4	32.4	1	27.40			1	5.0	2	0
2	Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль	4	83.4	3	78.9			1	4.5		
3	Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль	3	27	1	22.5			1	4.5	1	
4	Ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль	2	6.4			1	1.9			1	4.5
5	Ерөнхий боловсролын 5 дугаар сургууль	6	16.9	3	14.4			1	2.5	2	
6	Ерөнхий боловсролын 6 дугаар сургууль	3	16.4	1	13.9			1	2.5	1	
7	Ерөнхий боловсролын 7 дугаар сургууль	2	2.5					1	2.5	1	
8	Ерөнхий боловсролын 8 дугаар сургууль	8	226.3	7	14.1			1	212.2		
9	Ерөнхий боловсролын 9 дүгээр сургууль	2	3.9					1	3.9	1	
10	Ерөнхий боловсролын 10 дугаар сургууль	4	48	1	36.9	1	3.7	1	3.9	1	3.5
11	Хотгор багийн ЕБС	2	23.3	1	19.4			1	3.9		
12	Өлгий 1 дүгээр цэцэрлэг	2	3.9					1	3.9	1	
13	Өлгий 2 дугаар цэцэрлэг	6	142.2			1	22.7	3	116.4	2	3.1
14	Өлгий 3 дугаар цэцэрлэг	6	376.8	1	87.8	1	1.0	1	2.5	3	285.5
15	Өлгий 4 дүгээр цэцэрлэг	1	0							1	
16	Өлгий 5 дугаар цэцэрлэг	3	1					1	1.0	2	
17	Өлгий 6 дугаар цэцэрлэг	2	3.9					1	3.9	1	
18	Өлгий 7 дугаар цэцэрлэг	4	5.4					1	5.4	3	
19	Өлгий 8 дугаар цэцэрлэг	2	3.9					1	3.9	1	
20	Өлгий 9 дүгээр цэцэрлэг	3	7.6	1	2.6			1	5	1	
21	Өлгий 10 дугаар цэцэрлэг	1	3.9					1	3.9		

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

22	Өлгий 11 дүгээр цэцэрлэг	3	2.8					3	2.8	
23	Өлгий 12 дугаар цэцэрлэг	3	3.9				1	3.9	2	
24	Өлгий 13 дугаар цэцэрлэг	3	99.8	1	95.8		1	4.0	1	
25	Өлгий 14 дүгээр цэцэрлэг	3	32.1				1	1.5	2	
26	Өлгий 15 дугаар цэцэрлэг	3	1.5				1	1.5	2	
27	Өлгий 16 дугаар цэцэрлэг	5	17.2	2	12.2		1	5.0	2	
28	Өлгий 17 дугаар цэцэрлэг	2	2.9				1	2.9	1	
29	Өлгий 18 дугаар цэцэрлэг	4	4	1	0.1		1	3.9		
30	Өлгий 19 дүгээр цэцэрлэг	3	5				2	5.0	1	
31	Өлгий 20 дугаар цэцэрлэг	3	176.8				2	176.8	1	
32	Өлгий 21 дүгээр цэцэрлэг	3	5				1	5.0	2	
33	Өлгий 22 дугаар цэцэрлэг	3	24.4				1	2.5	2	
34	Өлгий 23 дугаар цэцэрлэг	3	10.4				1	3.9	2	
35	Өлгий 24 дүгээр цэцэрлэг	4	20.3	1	16.4		1	3.9	2	
36	Өлгий 25 дугаар цэцэрлэг	3	2.5				1	2.5	2	
37	Өлгий 26 дугаар цэцэрлэг	6	20.9	6	20.9					
38	Өлгий 27 дугаар цэцэрлэг	1	61.9				1	61.9		
39	Өлгий 32 дугаар цэцэрлэг	1	4.7	1	4.7					
40	Хотгор багийн цэцэрлэг	2	27.3				1	3.9	1	
41	Хотгор Эрүүл мэндийн төв	0	0							
42	Өрхийн ЭМТ-үүд	15	694.7	13	461.1				2	
<b>Бусад байгууллагын дүн</b>		<b>143</b>	<b>2253.2</b>	<b>45</b>	<b>929.1</b>	<b>4</b>	<b>29.3</b>	<b>39</b>	<b>679.4</b>	<b>55</b>
<b>Нийт дүн</b>		<b>158</b>	<b>3302.4</b>	<b>45</b>	<b>929.1</b>	<b>9</b>	<b>47.0</b>	<b>45</b>	<b>1371.6</b>	<b>59</b>

Эх сурвалж: Аудитын зөрчлийн мэдээ

Аудитын дүнгээр Сумын Засаг дарга, Санхүүгийн албад дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

1.Сумын төсөвт байгууллагуудын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчилд өгсөн зөвлөмж, албан шаардлага, төлбөрийн актын биелэлтэд хяналт тавьж, үр дүнг тайлагнаж ажиллах;

## 5.2. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын дүнгийн талаар:

Сумын ТТЗ-ийн нэгтгэсэн санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй, алдаа зөрчил илрээгүй болно.

Аудитаар сумын ТТЗ-д 1 заалт бүхий зөвлөмж өгсөн.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмж, албан шаардлагын биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа	Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан	Буруу тусган илэрхийлсэн	Үүнээс		Зөвлөмж
				Залруулсан	Залруулаагүй	
/мянган төгрөгөөр/						

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	Тоо	Дүн										
<b>Дүн</b>												

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ТТЗ-ийн харьяа байгууллагуудад өгсөн аудитын шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тайлагнах	1							1				
<b>Дүн</b>	<b>1</b>							<b>1</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
<b>Дүн</b>								
Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
<b>Дүн</b>								
<b>Нийт дүн</b>								